



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д. Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА С.БЯМБАЦОГТ ТАНАА

2025. 09. 22 № 41

**Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийн
талаарх мэдээлэл ирүүлэх тухай**

Монгол Улсын Их Хурал 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдөр Зөвшөөрлийн тухай хуулийг баталж, хууль хэрэгжиж эхэлснээс хойш багагүй хугацаа өнгөрч байна.

Уг хуулийг Улсын Их Хурлын хэлэлцүүлгийн шатанд ахалж ажилласан гишүүний хувьд хууль батлагдан, хэрэгжиж эхэлснээс хойш Улсын Их Хурлын хянан шалгах бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Засгийн газраас асуулт, асуулга тавих, хууль тогтоомжийн биелэлтийг хангахтай холбогдох үйл ажиллагааг хэрэгжүүлсээр байна.

Энэ хүрээнд зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон актыг хүчингүйд тооцуулах зохицуулалт, төрийн нийтийн өмч, байгалийн баялгийг ашиглахтай холбоотой зөвшөөрлийг шударга өрсөлдөөний зарчмыг баримтлан дуудлага худалдаа, эсхүл сонгон шалгаруулалтаар явуулах зохицуулалт, зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих, Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах үндэслэл, шаардлагын талаар санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн Зөвлөлийн ажиллах журмын зохицуулалт, зөвшөөрлийн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт болон хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах асуудал тодорхой хэмжээнд хэрэгжиж байгаа хэдий ч хуулийн зарим зохицуулалттай холбоотой иргэн, аж ахуйн нэгжээс ирүүлж буй санал, гомдолд үндэслэн хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа дараах асуудалд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлд тус тус заасны дагуу дараах асуулгыг тавьж байна.

Нэг.Зөвшөөрлийн тухай хуулийн 1.3 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг:

Хүн, хуулийн этгээд хуулиар хориглосон, эсхүл зөвшөөрөлтэйгөөр эрхлэхээс бусад төрлийн үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн чөлөөтэй эрхлэх асуудлыг болон хуулиар зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагааг эрхлэх, эсхүл байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглахад зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг тухайлсан хуулиар зохицуулснаас бусад харилцааг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна гэж хуульчилсан. Гэтэл зарим төрийн байгууллагаас чөлөөтэй эрхлэх боломжтой үйл ажиллагааг “БҮРТГЭЛ, ЭРХ ОЛГОЛТ” зэрэг баримт бичгээр зөвшөөрөлтэйгөөр эрхлүүлэх, хуулиар тусгайлан олгосон эрх хэмжээний харилцааг журмаар өргөжүүлж байгаагаас гадна бүртгэлгүй захиргааны хэм хэмжээний актаар зөвшөөрөл олгож байна.

2025000070

Тухайлбал, чөлөөтэй эрхлэх боломжтой зочид буудал, дэн буудал, амралтын газрын үйл ажиллагааг Нийслэлийн аялал жуулчлалын газар тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлүүлж байгаагаас гадна бусад төрийн байгууллагаас зөвшөөрөлгүй эрхлэх үйл ажиллагаанд тавигдах шаардлага бий болгож, тухайн шаардлагад зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагаанд шаардлагаас илүү баримт бичиг шаардаж, иргэн, аж ахуйн нэгжид хүндрэл учруулсаар байна.

Иймд төрийн байгууллагуудаас чөлөөтэй эрхлэх боломжтой үйл ажиллагааг зөвшөөрөлтэйгөөр эрхлүүлж байгаа үйл ажиллагааны жагсаалтыг байгууллага тус бүрээр гаргаж, үүнтэй холбоотойгоор хийгдэж буй ажлын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл.

Хоёр.Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 15 дахь хэсэг, 3.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 7.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг:

Зөвшөөрлийн тухай хуулиар зөвшөөрлийг шинээр бий болгоход тухайн үйл ажиллагааг төрөөс зохицуулах шаардлагатай эсэх, зөвшөөрөл нь зохицуулалтын зохистой арга хэрэгсэл мөн эсэх, зөвшөөрөл нь нийгэм, эдийн засгийн хувьд үр ашигтай байх эсэхэд судалгаа, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аргачлалыг, хуульд заасан тохиолдолд эрх бүхий этгээд зөвшөөрөл олгох эрхээ бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн төрийн холбогдох байгууллага, албан тушаалтан, эсхүл нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд шилжүүлж болох бөгөөд эрх шилжүүлэх журам батлахыг Засгийн газарт хуулиар тусгайлан эрх олгосон байна.

Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн боловч холбогдох хэм хэмжээ тогтоосон захиргааны акт батлагдаагүйн улмаас хууль нэг мөр хэрэгжих боломжгүйд хүрч, эдийн засаг, нийгмийн харилцаанд болон бусад үйл ажиллагаанд саад учруулах, авлигажих, хүнд суртал бий болох, хүний эрхэд халдах шалтгаан, нөхцөлийг бүрдүүлэх сөрөг үр дагаврууд гардаг.

Иймд дээрх аргачлал, журам батлагдсан эсэх, батлагдсан бол хэрэгжилтийн талаарх мэдээлэл, батлагдаагүй бол шалтгаан нөхцөлийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл.

Гурав.Зөвшөөрлийн тухай хуулийн 2.3 дугаар зүйл, 7.1 дүгээр зүйл, 7.2 дугаар зүйл:

Зөвшөөрлийн тухай хуулиар зөвшөөрлийн нэгдсэн бүртгэл хөтлөх, статистик мэдээг эрхлэн гаргах, лавлагаа өгөх, цахим хэлбэрээр зөвшөөрөл олгох зорилгоор зөвшөөрлийг кодлох бөгөөд эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцахаар хуульчилсан.

Зөвшөөрлийг кодоор баталгаажуулах нь төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, хуурамч зөвшөөрөл олголт болон авлигын эрсдэлийг бууруулах, төрийн үйлчилгээний үр ашиг, хяналтын чадавхыг нэмэгдүүлэх, иргэн, хуулийн этгээдийн хувьд үйлчилгээ авах үйл явцыг хялбаршуулж, цаг хугацаа, зардлыг хэмнэх, бизнесийн орчны итгэлцлийг бэхжүүлэх ач холбогдолтой бөгөөд дижитал засаглалын чадавхыг дээшлүүлэх стратегийн чухал хэрэгсэл юм.

Иймд зөвшөөрлийг кодлох ажлын хүрээнд хийгдэж буй ажлын талаарх мэдээлэл болон зөвшөөрлийн нэгдсэн сангийн мэдээлэл, зөвшөөрлийг цахимаар шийдвэрлэж байгаа талаарх дэлгэрэнгүй мэдээлэл.

Дөрөв.Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 2.3, 2.6, 2.9 дахь заалт, 7.1 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг:

Зөвшөөрөл хүссэн болон сунгуулах өргөдлийг хүлээн авах, өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг магадлан шалгах, шийдвэр гаргах үйл ажиллагааны явцыг зөвшөөрөл хүсэгч,

зөвшөөрөл эзэмшигчид, зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг олон нийтэд цахим хэлбэрээр, нээлттэй, ил тод байлгах асуудлыг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулсан.

Гэтэл өнөөдрийг хүртэл зөвшөөрлийн цахимжуулалтын хэрэгжилт хангалтгүй байгаа бөгөөд төрийн байгууллагад цаасан хэлбэрээр баримт бичиг бүрдүүлж, хүсэлт, өргөдөл өгдөг хэвээр байна.

Тухайлбал, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга, эсхүл чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт чөлөөт бүсийн захирагч олгохоор хуульчилсан байх бөгөөд энэ зөвшөөрлийг авахад тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон өргөдөл хүлээн авч шийдвэрлэх асуудал нь өнөөдрийг хүртэл мэдээлэл нь тодорхойгүй, ойлгомжгүй, цахимжаагүй байна.

Иймд зөвшөөрлийг цахимжуулахтай холбоотой хийгдэж буй бүхий ажиллагааны дэлгэрэнгүй мэдээлэл.

Тав.Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:

Зөвшөөрлийн тухай хуулиар иргэн, хуулийн этгээдийн зөвшөөрөл хүссэн өргөдлийг шийдвэрлэхдээ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд зааснаар төр өөрт байгаа мэдээллээ иргэн, аж ахуй нэгжээс шаардахгүй буюу төрийн байгууллага хоорондоо мэдээллийг солилцож, гаргуулан авах зохицуулалтыг тусгасан.

Гэтэл зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд буюу төрийн байгууллагууд мэдээллээ солилцдоггүйн улмаас иргэн, аж ахуйн нэгжийг хүндрүүлж, хүнд суртал гаргаж, өөр төрийн байгууллагад байх мэдээллийг заавал шаардаж авдаг байдал хэвээр байна.

Тухайлбал, Монголбанканд үнэт металл тушаахад бүрдүүлэх материалын жагсаалтыг Монголбанкнаас гаргасан байх бөгөөд уг жагсаалтад Үнэт металлын арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагыг тавьсан байна. Үнэт металлын арилжаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 2.20-д Санхүүгийн зохицуулах хороо олгохоор хуульд туссан байна.

Иймд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд зааснаар төрд байгаа мэдээллийг төрийн байгууллага хооронд солилцож байгаа ажлын тайлан.

Зургаа.Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйл:

Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1-д зааснаар 2 чиглэлийн 7 тусгай зөвшөөрлийг дуудлага худалдааны журмаар, 6 чиглэлийн 18 тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын журмаар явуулахаар заасан байна.

Иймд Зөвшөөрлийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн цагаас хойш дуудлага худалдаа, сонгон шалгаруулалтын тоон мэдээлэл болон дуудлага худалдаа, сонгон шалгаруулалтын босго үнэ, төсөвт төвлөрсөн мөнгөн дүн, зарцуулалтын талаарх нэгдсэн дэлгэрэнгүй мэдээлэл.

Мөн зүйлийн 2-т дуудлага худалдаа, сонгон шалгаруулалтын журмыг тухайлсан хуулиар нарийвчлан зохицуулах асуудлыг хуульчилсан. Үүнтэй холбоотой хийгдэж буй ажлын мэдээлэл.

Долоо.Зөвшөөрлийн тухай хуулийн 6.5 дугаар зүйлийн 1.8 дахь заалт:

2025000070

Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1, 8.2 дугаар зүйлд зааснаар 377 үйл ажиллагааг иргэн, хуулийн этгээд зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд үйл ажиллагаа эрхлэхдээ Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасан хураамжийн хэмжээгээр, хуульд заасан журмын дагуу төлөх хуулийн зохицуулалттай.

Гэтэл Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээ тэгш бус, ялгамжтай байгаа талаар иргэн, хуулийн этгээдээс гомдол ирүүлсээр байна.

Тухайлбал, эрчим хүчний барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл олгоход 25,000 төгрөг, барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл олгоход 500,000-1,250,000 төгрөг байгаа нь хууль тодорхой биш, ойлгомжгүй, ялгаатай байдлыг бий болгож байна.

Иймд Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3-т заасны дагуу улсын нэгдсэн тайлангийн мэдээллийг тусгай, энгийн зөвшөөрөл тус бүрээр сүүлийн 3 жилийн статистик мэдээлэл.

Мөн тусгай, энгийн зөвшөөрлийг эрсдэлийн түвшингөөр ангилж, түүнтэй уялдуулан эдийн засгийн бодит тооцоололд үндэслэн тэмдэгтийн хураамжийн хэмжээг тогтоох, хөнгөлөх, чөлөөлөх, төлөх, хураах асуудалд хийгдэж буй ажлын мэдээлэл.

Найм.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1, 8.2 дугаар зүйл:

Тусгай энгийн зөвшөөрлийг зөвшөөрөл тус бүрээр 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш шинээр олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон шийдвэрийн талаарх тоон статистикийн нэгдсэн мэдээлэл.

Ес.Зөвшөөрлийн тухай хуулийн 9.2 дугаар зүйл:

Зөвшөөрөл, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь Зөвшөөрлийн тухай хуулийн зорилго, зарчим, нөхцөл, шаардлагад нийцэж байгаа эсэхэд хуульд заасан шалгуур үзүүлэлтээр хяналт, шинжилгээ, эрсдэлийн үнэлгээг гурван жил тутамд хийх, хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүнг үндэслэн тухайн зөвшөөрлийг хэвээр үлдээх, эсхүл зөвшөөрлийг нэг ангиллаас нөгөөд шилжүүлэх, эсхүл зөвшөөрлийн жагсаалтаас хасах, өөрчлөх асуудлаар хуулийн төсөл боловсруулах асуудлыг хуульчилсан.

Зөвшөөрлийн тухай хуульд 13 чиглэлээр 254 тусгай зөвшөөрлийг давхардсан тоогоор 89 эрх бүхий этгээд, 12 чиглэлээр 123 энгийн зөвшөөрлийг давхардсан тоогоор 36 эрх бүхий этгээд зөвшөөрөл олгохоор заасан байна.

Гэтэл салбар хоорондын уялдаа, хууль хоорондын нийцлийг хангаагүйгээс аль нэг салбарт үйл ажиллагаа явуулах гэж буй иргэн, аж ахуйн нэгж 2 ба түүнээс дээш төрийн байгууллагаас зөвшөөрөлтэй дүйцэхүйц баримт бичгийг заавал авах зохицуулалт хэвээр байна.

Тухайлбал, иргэн өөрийн өмчлөл, эзэмшилд буй газрыг худалдах, худалдан авахад Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээдээр байгаль орчны нарийвчилсан үнэлгээг хийлгэх, мөн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээдээр газрын төлөв байдлын үнэлгээг хийлгэх асуудлыг салбарын хууль, холбогдох журамд заасан байгаа нь агуулгын хувьд зарчмын ялгаагүй үнэлгээг 2 өөр төрийн байгууллагаас зөвшөөрөл авсан хуулийн этгээдээр хийлгэхээр зохицуулсан байгаа нь иргэнд эдийн засгийн болон нийгмийн бусад харилцааны хохирол учруулж байна.

Зөвшөөрлийн тухай хуульд заасан тусгай, энгийн зөвшөөрөлд дүн шинжилгээ, эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх, мөн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийн хуулиар олгосон чиг үүрэг болон салбарын хууль тогтоомжийн давхардал, хийдэл, уялдааг хангах арилгах асуудалд хийгдэж буй ажлын талаарх мэдээлэл.

Арав.Зөвшөөрлийн тухай хуулийн 9.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

Зөвшөөрлийн тухай хуулиар бизнес эрхлэгчдэд хүндрэлгүй, чөлөөтэй үйл ажиллагааг явуулах боломжийг хангах үүднээс тусгай, энгийн зөвшөөрлийг зохистой хэмжээнд барих зарчмыг тодорхойлсон. Энэ үүднээс Зөвшөөрлийн тухай хуульд зөвшөөрлийг шинээр бий болгох тохиолдолд хууль санаачлагч Нийтийн сонсголын тухай хуульд заасны дагуу хууль тогтоомжийн төслийн сонсгол явуулах, мөн Зөвлөл хуульд заасан шалгуур үзүүлэлтээр зөвшөөрөл нэмэх дүгнэлтийг гаргаж Засгийн газарт танилцуулснаар тухайн зөвшөөрлийг нэмэх эсэх асуудлыг шийдвэрлэхээр хуульчилсан.

Мөн Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Хууль санаачлагч тодорхой хууль санаачлах бол ... холбогдох бусад хууль тогтоомжид заасан хүрээ, хязгаарт нийцүүлэн, хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.” гэж заажээ.

Гэтэл хуулийн хүрээ хязгаарт нийцүүлэлгүй Зөвшөөрлийн тухай хуульд тусгай, энгийн зөвшөөрөл нэмэх асуудлыг тусгасан хуулийн төслийг өргөн барих тохиолдол гарсаар байна.

Хууль хэрэгжиж эхэлснээс хойш шинээр зөвшөөрөл нэмэх асуудалд хуулийн хүрээ хязгаар, шаардлагад нийцсэн, дүн шинжилгээнд үндэслэн нэмсэн зөвшөөрлийн нэгдсэн мэдээлэл.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН


Х.ГАНХУЯГ

2025000070